



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар A/356

Хэрлэн сум

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн сарын аянд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гурав дугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.5 дахь хэсэгт заасан тул Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



۹ صفتیں

نکات مهم